



БСШУ-НЫ ЯАМНЫ ХАРЬЯА МОНГОЛ- ЭНЭТХЭГИЙН ХАМТАРСАН СУРГУУЛЬ

*Д.Гантөмөр
/Монгол - Энэтхэгийн
хамтарсан сургуулийн захирал/*

Хүүхдийн техник сэтгэлгээ, зохион бүтээх авьяас сонирхлыг хөгжүүлэхэд техникийн төрөлжсөн сургалттай сургууль шаардлагатай байгааг харгалзан 1991 онд Залуу Техникчдийн Ордныг “Өсвөрийн Зохион Бүтээгчдийн Төв Сургууль” болгон өөрчлөн зохион байгуулснаар тус сургуулийн эхлэл тавигдсан юм.

2003-2004 оны хичээлийн жилээс Монгол улсын засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг улсын засгийн газар хооронд боловсролын салбарт хамтран ажиллах талаарх харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу БСШУ-ны сайдын 316-р тушаалаар БСШУЯ-ны харьяа Монгол-Энэтхэгийн хамтарсан ерөнхий боловсролын дунд сургууль болгон шинэчлэн, 4 дэх жилдээ хичээллэж байна.

Монгол - Энэтхэгийн хамтарсан сургууль нь математик, мэдээлэл зүй, англи хэл, химийн хичээлээр гүнзгийрүүлсэн сургалт явуулахаас гадна, уламжлал болон явагдаж ирсэн сурагчдын техник сэтгэлгээ, зохион бүтээх авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн техник технологийн сургалтыг давхар явуулж байна.

Тус сургууль нь 50 орчим багш ажилчидтай, 8-11 дүгээр ангийн 16 бүлэгт 500 гаруй сурагчтайгаар хичээллэж байна. Нийт багш нарын дотор доктор 1, магистр 16 байгаагаас гадна мэргэжлийн зэрэгтэй багш нар 68%-ийг нь эзэлж байна. БНЭУ-аас англи хэлний 3 багш, математикийн 1 багш, компьютерийн мэргэжлийн 1 багш уригдан ирж 4 дэх жилдээ ажиллаж байна.

Бүх суралцагчид англи хэлний хичээлийг нэмэлт цагаар судалж, БНЭУ-аас уригдан ирсэн өндөр мэргэжлийн багш нар зааж байна. Мөн математикийн гүнзгийрүүлсэн сургалттай бүлгүүдэд математик, компьютерийн хичээлүүдийг энэтхэг багшаар заалгаж байгаа нь тухайн хичээлийг англи хэл дээр судлах боломжийг нээж өгч байна.

Тус сургуульд суралцагсад нь 8 -11 жилийн сургалтанд хамрагдаж суралцах хугацаандаа математик, гадаад хэл, хими, мэдээлэл зүйн мэргэжлийн чиглэлээр өндөр мэдлэг эзэмшиж, өөрийн сонирхсон техник технологийн чиглэлээр мэргэжлийн анхан шатны мэдлэг, чадвар, дадалтай болж, Энэтхэгийн соёл, зан заншил, түүхийг судалж мэдсэн байхаар шинэчлэн боловсруулсан стандартын дагуу сургалт явагдаж байна.

Шинэ стандарт, каррикулумыг хэрэгжүүлэх, багш нарын мэргэжил, заах арга зүйн чадварыг дээшлүүлэх үүднээс өөрийн сургуулийн багш нарт БНЭУ-ын боловсролын систем, үнэлгээний системийн талаар танилцуулах, сургалтын арга

барилдаас багш нар харилцан суралцах, туршлага судлах, БНЭУ-д багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зэрэг ажлуудыг хийж байна.

Энэ хичээлийн жилээс Энэтхэг улсын буцалтгүй тусламжаар Теле - боловсролын хөтөлбөрийн хүрээнд 24 цагийн ажиллагаатай Теле боловсролын төв нээхээр бэлтгэл ажилдаа ороод явж байна. Теле-боловсролын систем нь алс хол байгаа сурагчдад электрон мэдээлэл болон холбоо харилцааны технологийг ашиглан, боловсролын хангамжийг хүргэснээр тэднийг сурах чадвараа дээшлүүлэхэд ач холбогдолтой юм. Энэ нь сурагчдыг цогц байдлаар хөгжих бололцоог олгохын зэрэгцээ нэртэй эрдэмтэдтэй харилцах боломжоор хангаж өгснөөр тэдний сурах урам зоригийг нэмэгдүүлнэ. Мөн Теле-боловсролын системийн арга нь хичээл заах үед багш, сурагчдын өмнө тулгардаг харилцааны бэрхшээлийг даван туулахад тусгай бөгөөд орон зайн хязгаараас үл хамааран эрчимтэй сурах боломжийг олгодог чухал ач холбогдолтой.

Цаашид Монгол - Энэтхэгийн хамтарсан сургуулийг өргөтгөн 1-12 дугаар ангитай, англи хэл, математик, мэдээлэлийн технологи дээр суурилсан үлгэр жишээ, загвар Ерөнхий боловсролын сургууль болгох төслийг Энэтхэг багш нартай хамтран боловсруулж, холбогдох дээд байгууллагуудад танилцуулаад дэмжигдсэн нь Монгол улсын засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг улсын засгийн газар хооронд байгуулсан гэрээний заалтын дагуу баталгаат зэрэглэлтэй сургууль болох боломж бүрдэж байна гэж үзэх үндэслэлтэй болж байна.

Тус сургууль нь улс, нийслэл, дүүргийн хэмжээнд зохиогддог Физик, Математик, Хими, Биологи, Монгол хэл, Англи хэл, Техник технологийн олимпиадуудад амжилттай оролцож, багийн болон хувийн амжилтаар тэргүүн байр, медальт байруудад удаа дараа шалгарч ирлээ. Үүнээс заримыг дурьдвал:

- Физикийн хичээлээр: 2006 онд "Бүх нийтийн физик боловсролыг дэмжих Физикийн багийн олимпиадад"
- 10-р ангийн төрөлд багаараа 1-р байр
- 9-р ангийн төрөлд багаараа 3-р байр.
- 8-р ангийн төрөлд багаараа 4-р байр эзэлж Өргөмжлөлөөр шагнагджээ.
- Мөн Гадаад хэргийн сайдын ивээл дор зохиогдсон англи хэлний улсын олимпиадад: 11а ангийн сурагч О.Чингүн 2-р байр Мөнгөн медаль,
- 11в ангийн сурагч Б.Жавхлан нь энэ хичээлийн жилд "Монгол Ньюс" компани үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ойд зориулан UB Post сонины газраас зохион байгуулсан ЭССЭ бичлэгийн уралдаанд Тэргүүн байр эзэлж, ивээн тэтгэгч "Спирт бал Бурам" ХХК-ий их дээд сургуулийн тэтгэлгээр,
- Мөн 11в ангийн сурагч Б.Жавхлан, 8б ангийн сурагч Г.Халиун нар Сурагч Солилцооны Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан Англи хэлний Уралдаанд амжилттай оролцож Хүрэл медаль, Австрали улсын олон улсын хүүхдийн зусланд амрах эрхийн бичгээр,
- 10 б ангийн сурагч Мөнхтуяа "New Face" загвар өмсөгчийн тэмцээнд амжилттай оролцож - "2007 оны шинэ дүр төрх" Өргөмжлөлийн эзэн,
- 10г ангийн сурагч Б.Батсанаа СӨҮЛ-ийн Соёл Мэдээллийн Төвийн 10 жилийн ойг угтан "СӨҮЛИЙН ТУСГАЛ" эссэ бичлэгийн уралдаанд дэд байр эзэлж, МХО-ны "Эрдэм" мөнгөн медаль, ивээн тэтгэгч байгууллагын

- мөнгөн шагналаар,
- 11Г ангийн сурагч З.Маргад Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн мэндэлсний 100 жилийн ой угтан БСШУЯ-аас орон даяар зарласан “Д.Нацагдорж - миний амьдрал” сэдэвт эссэ, зохион бичлэгийн уралдаанд шалгаран дэд байр эзэлж ивээн тэтгэгч байгууллагын мөнгөн шагналаар шагнагдсан.
 - Нисэх загварын төрлөөр: уран жолоодлогот нислэгээр 11А ангийн сурагч Ц.Төгөлдөр 2-р байр мөнгөн медаль,
 - Усан загварын төрлөөр: 11А ангийн сурагч О.Золбаяр 1-р байр, алтан медаль мөн усан загварын төрөл жолоодлогот загварын төрлөөр 11А ангийн сурагч Г.Дөлгөөн 1-р байр, алтан медаль.
 - Зураг дизайны төрлөөр: 10Г ангийн сурагч М.Эрдэнэцэцэг 5-р байр, тусгай шагналаар шагнагдлаа.
 - Компьютер дизайн чиглэлээр: Нийслэлийн олимпиадад 11В ангийн сурагч Ц.Мөнхзаяа 2-р байр мөнгөн медаль, 11Г ангийн сурагч Анхбаяр 3-р байр хүрэл медаль авч, амжилт бүтээлээр дүүрэн байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар тус сургуулийн 11 дүгээр анги төгсөгчид 100% их, дээд сургууль, коллежид элсэн орсноос 61% нь гүнзгийрүүлсэн буюу мэргэжлийн сургалтын чиглэлээрээ их дээд сургуульд элсэн орж байгаа нь сургуулийн сургалтын чанар, монгол, энэтхэг багш нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварын үр дүн гэж зүй ёсоор үзэх ёстой.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар, Энэтхэгийн хүний хөгжил, нөөцийн яамтай байгуулсан боловсролын салбарт хамтран ажиллах Гэрээний дагуу англи хэл, математик, компьютерийн өндөр мэргэжил боловсролтой, ерөнхий боловсролын дунд сургуульд олон жил ажилласан, хүүхэдтэй ажиллах мэдлэг, ур чадвар сайтай багш нарыг манай сургуульд багшлуулахаар илгээсэнд бид маш их талархаж байдаг.

Манай сургуулийн мэргэжлийн энэтхэг багш нар монгол хүүхэдтэй ажиллах арга барилд маш хурдан дадаж, сурагчдын дунд зохион байгуулагдаж байгаа Энэтхэг бүжгийн баяр, Дивали баяр, англи хэлний баярын өдрүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж, сурагчид маш идэвхитэй оролцдог болсон ба анги бүр энэтхэг бүжгийн охидын хамтлагтай болж чадсан.

Иймээс ч жил бүр Бүгд Найрамдах Энэтхэг улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яам, Монгол-Энэтхэгийн Найрамдалын Нийгэмлэгээс зохион байгуулдаг “Энэтхэг бүжгийг хэн сайн бүжиглэх вэ?” уралдаанд тогтмол оролцож, тэргүүн байранд шалгардаг.

Мөн багш Shenbaga Nathan, Deshai Reddy, Chitra Hunt, M.SriniVasan нар англи хэлний заах аргын гарын авлага, математикийн хичээлээр багш сурагчдад ашиглах англи-монгол бяцхан толь бичиг гаргаж ашиглаж байгаа нь багш сурагчдын талархлыг хүлээж, сургалтанд үр дүнгээ өгч байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Багш Shenbaga Nathan, Deshai Reddy, Chitra Hunt, M.SriniVasan нарын ажлыг үнэлж БСШУЯ-наас өргөмжлөл, НБШУ-ны газраас “Арга зүйч багш” цол тэмдгээр шагнасан юм.

Тухайн үед БСШУЯ-ны сайдаар ажиллаж байсан доктор А.Цанжид, Монгол улсаас Бүгд Найрамдах Энэтхэг улсад элчин сайдаар ажиллаж байсан доктор О.Нямдаваа нар Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуулийг анх үүсгэн байгуулахад бодит хувь нэмэр оруулсныг зүй ёсоор дурьдах ёстой. Иймээс ч сургуулийн Удирдах Зөвлөл, хамт олны хурлаас шийдвэр гаргаж доктор О.Нямдавааг сургуулийн хүндэт дэвтэрт мөнхжүүлэн тэмдэглэж “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнасан билээ.

Мөн хоёр засгийн газрын Гэрээний заалтыг хэрэгжүүлэх, Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуулийг үлгэр жишээ загвар сургууль болгох санаачлага гаргаж, чин сэтгэлээсээ дэмжин ажиллаж байсан Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол улсад сууж байсан элчин сайд ноён Gauri Shankar Gupta -г Монголын багш нарын Холбооноос “Есөн эрдэнэ” одонгоор шагнасан явдалд бид сэтгэл хангалуун байдаг юм.

Боловсролын салбар дахь хоёр орны удаан жилийн түүхэн хэлхээ холбоо улам бадран хөгжих болтугай.